

САНХҮҮГИЙН ХӨРӨНГИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛЫН АРГА ЗҮЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Д.Бунчинсүрэн*, Д.Нямаа**

Хураангуй: Бизнесийн практикт хэрэглэгдэж байгаа олон төрлийн санхүүгийн хэрэглүүр, санхүүгийн гэрээ хэлцэл болон даяаршилтай холбоотойгоор сүүлийн арав гаруй жилийн хугацаанд холбогдох нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналд мөрдөгдөх олон улсын стандарт (СТОУС 9) нилээд хэмжээгээр өөрчлөгдөж, тавигдах шаардлага зарчмын хувьд өмнөхөөс ялгаатай болсон ба манай улсад ч уг стандартын мөрдөлттэй холбоотой бэрхшээл тулгарсаар байгаа юм. Бидний энэхүү судалгааны ажлын зорилго нь санхүүгийн хөрөнгийг СТОУС 9-ийн дагуу нягтлан бодох бүртгэлд тусгаж, санхүүгийн тайланд толилуулах арга зүйг тодорхойлж, стандартын хэрэгжилттэй холбоотой практикт тулгарч буй асуудлуудыг судлан тогтоож, түүнийг зохистойгоор шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхэд оршиж байна.

Түлхүүр үгс: Санхүүгийн хэрэглүүр, санхүүгийн хөрөнгө, ашиг (алдагдал)-аарх бодит үнэ цэн, бусад дэлгэрэнгүй орлого болох бодит үнэ цэн, хорогдуулсан өртөг

ACCOUNTING AND FINANCIAL REPORTING ISSUES FOR FINANCIAL ASSETS

Abstract: Over the past decade, IFRS 9 have amended significantly. IFRS 9 requirements for recognition, measurement and impairment of financial instruments are intended to address the common needs of users worldwide.

In Mongolia, the implementation of IFRS 9 has been significantly delayed and we need to start adhering to this standard as soon as possible.

We have reviewed accounting and presentation requirements of financial instruments accordance with IFRS 9, practical issues related to the IFRS implementation and solutions in this article.

Key Words: financial instrument, financial asset, fair value through profit or loss, fair value through other comprehensive income, amortized cost

* МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail): bunchinsuren@num.edu.mn

** МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail): bunchinsuren@num.edu.mn

Оршил

Орчлон ертөнц дээрх юмс үзэгдэл байнгын хөгжил хөдөлгөөнд оршиж байдаг. Эдүгээ түгээмэл болсон зарим зүйлс өмнө нь бидэнд төсөөлөгдөж ч байгаагүй. Дэлхий даяар бизнесийн практикт олон төрлийн санхүүгийн хэрэглүүр, санхүүгийн гэрээ хэлцэл хэрэглэгдэж байна. Уламжлалт ойлголтоор хөрөнгө оруулалт, үнэт цаас гэх зэргээр нэрлэж ирсэн ухагдахууныг одоо санхүүгийн хэрэглүүр хэмээн нэрийдэх болсон. Энэ мэт олон шалтгааны улмаас сүүлийн арав гаруй жилийн хугацаанд санхүүгийн хэрэглүүрийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналд мөрдөгдөх олон улсын стандарт (СТОУС 9) үлэмж хэмжээгээр өөрчлөгдөж, тавигдах шаардлага зарчмын хувьд өмнөхөөс ялгаатай болсон. Энэ байдал нь уг стандартыг мөрдөж, санхүүгийн тайлан бэлтгэгч аж ахуйн нэгж, байгууллага төдийгүй стандарт боловсруулагч, бодлого тодорхойлогчид өмнөх байр суурь, бодлогоо эргэн харахад хүргэсэн.

СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр -ийг 2018 оны 1 дүгээр сарын 1-ээс мөрдөж эхэлснээс хойш НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт хүчингүй болсон нь санхүүгийн хэрэглүүр, тэр дундаа санхүүгийн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллагууд, ялангуяа санхүүгийн байгууллагуудын санхүүгийн тайлагналд мэдэгдэхүйц их нөлөөлж байсныг мэргэжлийн байгууллагуудын судалгааны үр дүн харуулж байна. Манай улсын хувьд санхүүгийн байгууллагууд НББОУС 39-ийг мөрдөж байгаа ба СТОУС 9-ийг нэвтрүүлэхтэй холбоотой бэрхшээл тулгарч, бид асуудлыг хараахан бүрэн шийдвэрлэж чадаагүй байна.

Санхүүгийн байгууллагуудын санхүүгийн мэдээлэл, тэр дундаа санхүүгийн хэрэглүүрийн тухай мэдээллийг үнэн зөв бүртгэж, тайлагнах нь мэдээлэл хэрэглэгчид шийдвэр гаргахад ач холбогдолтой.

Бидний энэхүү судалгааны ажлын зорилго нь санхүүгийн хөрөнгийг СТОУС 9-ийн дагуу ангилан, хүлээн зөвшөөрч, санхүүгийн тайланд толилуулах арга зүйг тодорхойлж, уг стандартын хэрэгжилттэй холбоотой олон улсын практикт тулгарч буй асуудлуудыг нэгтгэн дүгнэж, манай улсын нөхцөл байдалд түүнийг нэвтрүүлэх арга замыг эрэлхийлэхэд оршиж байгаа ба санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт, хейджийн бүртгэлийн асуудлыг нарийвчлан авч үзээгүй болно.

Ийнхүү СТОУС 9-ийг бүрэн нэвтрүүлж, санхүүгийн хэрэглүүрийн тайлагналыг олон улсын шаардлагад нийцүүлснээр дотоодын банк, санхүүгийн байгууллагын санхүүгийн мэдээллийн найдвартай байдал сайжирч, улмаар олон улсын зах зээлийн харилцаанд саадгүй оролцох, нэр хүнд бүхий санхүүгийн байгууллагатай харилцах, олон хэлбэрийн санхүүжилт авах боломж нэмэгдэх юм.

Энэхүү судалгааны ажилд СТОУС 9-ийн хэрэгжүүлэлттэй холбоотой тулгарч буй асуудлуудыг судалсан мэргэжлийн байгууллага, судлаачдын судалгааны үр дүн, зөвлөмжийг арга зүйн үндэс болгон ашигласан ба төрийн байгууллагуудаас батлан мөрдүүлж буй нягтлан бодох бүртгэлийн холбогдох заавар аргачлалыг судалж, тэдгээрийг СТОУС 9-д нийцүүлэн өөрчлөн сайжруулах замаар санхүүгийн

хөрөнгийн санхүүгийн тайлагналыг сайжруулах боломж байгаа гэсэн таамаглалыг бид дэвшүүлсэн.

Санхүүгийн хөрөнгийн эдийн засгийн мөн чанар

Бизнесийн байгууллагууд ашиг, орлогоо нэмэгдүүлэхийн тулд сул чөлөөтэй мөнгөн хөрөнгөөрөө янз бүрийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийхийг эрмэлздэг ба эрхэлж буй үйл ажиллагаандаа хамааралтай эрсдэлийг бууруулахын тулд санхүүгийн байгууллагатай төрөл бүрийн гэрээ хэлцэл хийх зэргээр санхүүгийн хэрэглүүрийг өргөн ашиглаж байна. Орчин үеийн санхүүгийн хэрэглүүр нь бонд гэх зэрэг уламжлалт энгийн хэрэглүүрээс эрс ялгаатай болсон ба тухайлбал үүнд дериватив буюу үүсмэл хэрэглүүр багтдаг. Түүнчлэн байгалийн үзэгдэлээс үүдэлтэй эрсдэлд өртөмхий бизнес эрхэлж буй хөдөө аж ахуйн фирм гэх мэт аж ахуйн нэгж байгууллага зарим санхүүгийн байгууллагатай “цаг агаарын дериватив” (weather derivative) хэлцэл хийсэн байдаг ба үүнийг мөн санхүүгийн хэрэглүүр гэж үздэг.

СТОУС-д тодорхойлсноор *санхүүгийн хэрэглүүр* гэж нэг аж ахуйн нэгжид санхүүгийн хөрөнгө, нөгөө аж ахуйн нэгжид санхүүгийн өр төлбөр эсвэл өмчийн хэрэглүүрийг бий болгож байдаг аливаа гэрээ хэлцлийг хэлнэ.[9] Энд тодорхойлсноор санхүүгийн хэрэглүүр нь санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөр, өмчийн хэрэглүүрийг аль алийг төлөөлсөн өргөн хүрээтэй ойлголт юм. Мөн түүнчлэн аливаа санхүүгийн хэрэглүүрийн үр дүнд уг хэлцэлд оролцогч аль нэг талын хувьд санхүүгийн хөрөнгө үүсэж байдаг. Тиймээс санхүүгийн хэрэглүүрт хамаарах нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын шаардлагын дийлэнх нь санхүүгийн хөрөнгөнд хамааралтай байдаг гэж дүгнэж болно.

СТОУС-д тодорхойлсноор *санхүүгийн хөрөнгө* гэж дараах зүйлийг ойлгоно [9]:

1. Мөнгө
2. Бусад аж ахуйн нэгжийн өмчийн хэрэгсэл
3. Бусад аж ахуйн нэгжээс мөнгө болон бусад санхүүгийн хөрөнгө авах гэрээний эрх эсвэл аж ахуйн нэгжид тааламжтай байх нөхцлөөр санхүүгийн хэрэгслийг бусад аж ахуйн нэгжтэй солилцох гэрээний эрх.

Иймээс санхүүгийн хөрөнгө хэмээн ойлголт нь мөнгөн хөрөнгө, дансны авлага, бонд, вексель гэх зэрэг өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт, өмчийн хэрэглүүр буюу хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт зэргийг багтааж байна.

Санхүүгийн хөрөнгө эзэмшдэггүй аж ахуйн нэгж, байгууллага гэж байхгүй бөгөөд ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны чиглэл, цар хүрээнээс хамааран санхүүгийн мэдээлэлд санхүүгийн хөрөнгийн талаарх мэдээллийн үзүүлэх үр нөлөө ялгаатай байж болох юм.

Өрийн хэрэглүүрийн хувьд санхүүгийн хөрөнгө нь ерөнхийдөө бусдаас мөнгө болон санхүүгийн хөрөнгө авахаар үүссэн гэрээний эрх юм. Тухайлбал, уламжлалт энгийн хэрэглүүр болох бонд, вексель, дансны авлага зэрэг нь тодорхой хугацааны

дараа эсвэл тогтсон хугацаанд багтаан уг хэрэглүүрийг эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага мөнгө хүлээн авах эрхтэй байдаг. Түүнчлэн энэ утгаараа төлсөн мөнгөө эргүүлэн авах эрх үүсдэггүй тул татварын хөрөнгө буюу бидний хэлж заншсанаар татварын авлага болон бараа үйлчилгээ худалдан авахаар төлсөн урьдчилгаа төлбөр, урьдчилж төлсөн зардлыг санхүүгийн хөрөнгө гэж үзэхгүй.

Харин өмчийн хэрэглүүрийн хувьд санхүүгийн хөрөнгө нь ерөнхийдөө хувьцаагаарх хөрөнгө оруулалт юм. Гэхдээ охин компани, хараат компани, хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг санхүүгийн хөрөнгөнд хамруулахгүй. Тиймээс эдгээрийг ялгаж салган үзэх ба тэдгээрт тавигдах санхүүгийн бүртгэл, тайлагналын шаардлага, мөрдөгдөх стандартууд ялгаатай байдаг.


Санхүүгийн хөрөнгийн ангилал

Санхүүгийн хөрөнгийг ямар үнэлгээгээр, хэрхэн тайлагнахад тавигдах шаардлага нь түүний ангиллаас хамаардаг. Иймд санхүүгийн хөрөнгийн ангиллыг зөв хийснээр түүний нягтлан бодох бүртгэл, холбогдох үнэлгээ, хэмжилт, санхүүгийн тайлагнал зохистой хийгдэх боломжтой болох юм.

СТОУС 9-ийн дагуу санхүүгийн хөрөнгийг анх бүртгэлд тусгахдаа хорогдуулсан өртөг, ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ, бусад дэлгэрэнгүй орлого болох бодит үнэ цэнэ зэрэг аргачлалаар илэрхийлдэг ба санхүүгийн хөрөнгийн ангиллыг ийнхүү үнэлгээ хэмжилтийг нь хийж буй аргачлалаар нэрлэдэг. Өөрөөр хэлбэл санхүүгийн хөрөнгийг дараах гурван ангиллаар ангилна. Үүнд:

- Хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө;
- Ашиг (алдагдал)-аарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө;
- Бусад дэлгэрэнгүй орлого болох бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө.

Зураг 1. Санхүүгийн хөрөнгийн ангилал



Санхүүгийн хөрөнгийг ангилахдаа дараах хоёр нөхцлийг зэрэг харгалзан үзэх ба эдгээр нөхцлийг хангаж байвал уг санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр илэрхийлнэ:

- Санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанар буюу тогтсон хугацааны дараа үндсэн өрийг эргүүлэн төлөгдөх болон тодорхой хугацааны давтамжтайгаар хүүний төлбөр төлөгдөх эсэх;
- Санхүүгийн хөрөнгийг удирдахаар аж ахуйн нэгж, байгууллагын сонгосон бизнесийн загвар буюу санхүүгийн хөрөнгийг худалдан авч, эзэмшиж буй зорилго. Өөрөөр хэлбэл уг санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн гүйлгээ буюу мөнгөн төлбөрийг цуглуулах зорилготой эсвэл уг санхүүгийн хөрөнгийг эргүүлэн худалдаж өгөөж хүртэх зорилготой эсэхийг харгалзана.

Өмчийн хэрэглүүрийн хувьд үндсэн төлбөр эргэн төлөгдөх эсвэл хүүний төлбөр гэж байхгүй тул гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанарыг хангахгүй. Иймд өмчийн хэрэглүүрт оруулсан аливаа хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртгөөр илэрхийлэх боломжгүй бөгөөд зөвхөн бодит үнэ цэнээр илэрхийлэхээр ангилна. Харин өрийн хэрэглүүрийн хувьд уг шалгуурыг хангах боломжтой байдаг тул санхүүгийн хөрөнгийн гурван ангилалд алинаар ч ангилж болно.

Түүнчлэн өмчийн хэрэглүүрийн хувьд арилжааны зорилгоор худалдан авч, эзэмшсэн эсэхийг харгалзан үзэх ба хэрэв ийм зорилготой бол ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэхээр ангилна. Түүнчлэн харьцангуй урт хугацаагаар эзэмшиж буй өмчийн хэрэглүүр нь дийлэнхдээ арилжааны зорилгогүй байдаг тул үүнийг бусад дэлгэрэнгүй орлого болох бодит үнэ цэнээр илэрхийлэхээр ангилна.

Дээрх шалгууруудаас гадна санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед бодит үнэ цэнээр илэрхийлэх сонголтыг ашиглан шууд бодит үнэ цэнээр илэрхийлэхээр ангилж болно. Тухайлбал, өмчийн хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх үед бусад дэлгэрэнгүй орлого болох бодит үнэ цэнээр илэрхийлэхээр ангилж, сонгож болно. Харин өрийн хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх үед дээрх шалгууруудыг хангаж байгаа эсэхийг үл харгалзан ашиг (алдагдал)-аарх бодит үнэ цэнээр илэрхийлэхээр ангилж болно.

Дериватив хэрэглүүрийн хувьд өрийн ба өмчийн хэрэглүүрийн аль ч шинжийг хангаж болохоос гадна нөхцөл байдлаас шалтгаалаад тааламжтай үед санхүүгийн хөрөнгө, тааламжгүй үед санхүүгийн өр төлбөрөөр хүлээн зөвшөөрөгддөг тул уг хэрэглүүрийг зөвхөн ашиг (алдагдал)-аарх бодит үнэ цэнээр илэрхийлэх ангилалд хамруулна.

Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн хөрөнгийг удирдах бизнесийн загвараа өөрчилсөн бол холбогдох санхүүгийн хөрөнгийн ангиллыг өөрчилнө.


Санхүүгийн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт /хөрөнгөнд тооцож санхүүгийн тайланд толилуулах үнэ цэнийг тодорхойлох тухай/

Санхүүгийн хэрэглүүр гэж үзсэн хэлцэлд аж ахуйн нэгж тал болон оролцсон бол уг санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.[9]

Санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрөх дээрх шалгуур нь *СТОУС-ын онолын* үзэл баримтлал болон бусад стандартуудад заасан хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуураас ялгаатай байна. Дээрх үзэл баримтлалд зааснаар нөөц орж ирэх магадлалтай бөгөөд өртөг буюу үнэлгээг нь найдвартай тооцон гаргах боломжтой үед хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Гэтэл санхүүгийн хэрэглүүрийн хувьд гэрээ хэлцэлийн нэг тал болсноор хүлээн зөвшөөрөх тул нөөц орж ирэх магадлалыг харгалздаггүйгээрээ ялгаатай байна.

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед бодит үнэ цэнээр хэмжих ба худалдан авалтын үнэ нь анх хүлээн зөвшөөрсөн өдрийн бодит үнэ цэнийг илэрхийлнэ. Бусад дэлгэрэнгүй орлого болох бодит үнэ цэнээр илэрхийлэх болон хорогдуулсан өртгөөр илэрхийлэх санхүүгийн хөрөнгийн анхны үнэлгээнд бодит үнэ цэнээс гадна ажил гүйлгээний өртөг багтдаг.

*Зураг 2. Санхүүгийн хөрөнгийн анхны хэмжилт
/бүртгэх үнэ цэнийг тодорхойлох нь/*



Ажил гүйлгээний өртөг гэж санхүүгийн хөрөнгийг олж эзэмших, данснаас хасахтай шууд холбоотой өсөн нэмэгдэх зардлыг ойлгоно.[9] Санхүүгийн хөрөнгийг хэрхэн ангилснаас хамааран ажил гүйлгээний өртгийг хэрхэн бүртгэх болон түүний анхны хэмжилт үнэлгээ ялгаатай тодорхойлогдоно. Иймд ангиллыг зөв хийх нь түүний санхүүгийн бүртгэл, тайлагналыг зохистой гүйцэтгэхэд ач холбогдолтой байдаг.

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараах үед бодит үнэ цэн болон хорогдуулсан өртгийн аль нэгээр хэмжиж, санхүүгийн тайланд толилуулна. Өөрөөр хэлбэл санхүүгийн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд толилуулахдаа ангилалд нь харгалзах энэхүү хоёр үнэлгээний аль нэгээр хэмжиж харуулдаг.

Бодит үнэ цэн

Санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр илэрхийлж, санхүүгийн тайланд тусгахдаа тайлангийн өдрөөр бодит үнэ цэнийн үнэлгээг хийж, харгалзах тохируулгыг гүйцэтгэнэ.

Бодит үнэ цэн нь ажил гүйлгээг бүртгэх өдөр зах зээлийн оролцогчдын хооронд хийгдэх зохих ёсны арилжаагаар хөрөнгийг худалдах үнэ юм.[9] Өөрөөр хэлбэл энэ нь санхүүгийн хэрэглүүрийн тухайн өдрөөрх идэвхитэй зах зээлийн жишиг үнийг хэлнэ. Хэрэв хэрэглүүрийн зах зээлийн үнийг тодорхойлох боломжгүй бол үнэлгээний аргыг

ашиглан бодит үнэ цэнийг тооцоолно. Тухайлбал, дискаунтчилсан мөнгөн гүйлгээний шинжилгээ, опционы үнийн загвар гэх зэрэг аргачлалаар үнэлгээг хийж болно.

Ашиг (алдагдал) -аарх бодит үнэ цэнийн хувьд санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өсөлт, бууралтыг тухайн тайлант хугацааны орлого, зардалд хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Харин бусад дэлгэрэнгүй орлого болох бодит үнэ цэнийн хувьд бодит үнэ цэнийн өсөлт, бууралтыг эздийн өмчийн дансанд хуримтлуулан бүртгэдэг. Эздийн өмчийн дансанд хуримтлуулж буй бодит үнийн өөрчлөлт нь орлого, зардлын тодорхойлолтыг хангадаг тул үүнийг “бусад дэлгэрэнгүй орлого” хэмээн мөн нэрлэж заншсан билээ.

Санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр илэрхийлсэн нөхцөлд түүний үнэ цэнийн бууралтыг тусгайлан тооцохгүй.

Зураг 3. Санхүүгийн хөрөнгийн дараа үеийн хэмжилт
/санхүүгийн тайланд толилуулах үнэ цэнийг тодорхойлох нь/



Хорогдуулсан өртөг

Хорогдуулсан өртөг гэж анхны өртгөөс үндсэн өрийн төлөлтийг хасч, үр ашигт хүүний аргаар тооцоолсон урамшууллын хорогдуулгы хасах эсвэл хямдруулалтын хорогдуулалтыг нэмж, үнэ цэнийн бууралтыг хассан дүнг хэлнэ.[9]

Үр ашигт хүүний түвшин нь санхүүгийн хэрэглүүрийн хүчинтэй байх хугацаанд ирээдүйн тооцоолсон мөнгөн төлбөр буюу мөнгөн орлогыг дискаунтчилан дансны цэвэр дүнг гаргах тохиромжтой хувь юм. Өөрөөр хэлбэл үр ашигт хүүний түвшин нь хөрөнгө, өр төлбөрийн ирээдүйн мөнгөн гүйлгээг анх хүлээн зөвшөөрсөн дүн болгон дискаунтчилах дундаж хувь байдаг.

Богино хугацаат санхүүгийн хөрөнгийн хувьд төлбөр төлөгдөх хугацаа ба уг хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсөн хугацааны хоорондын зөрүү бага байдаг тул төлөгдөх дүнгээр анх хүлээн зөвшөөрч бүртгэдэг бөгөөд санхүүгийн элемент агуулагддаггүй. Тиймээс ийм санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртгийг дийлэнхдээ

дансны үнэтэй нь тэнцүү гэж үздэг. Тухайлбал, дансны авлагыг энгийн байдлаар бүртгэж тайлагнадаг ба түүний хорогдуулсан өртгийн тооцоог нарийн төвөгтэй байдлаар тодорхойлох шаардлагагүй юм.

СТОУС 9 батлагдан гарснаар санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг бүртгэхдээ хэрэгжсэн зардлын загвар ашиглаж байсныг өөрчилж хэрэгжих зардлын загвар ашигладаг болгосон. Хэрэгжих зардлын загварын дагуу санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын хэрэгжих зээлийн зардлыг бүртгэхдээ гурван шаттай үнэ цэнийн бууралтын загварыг ашигладаг. Өөрөөр хэлбэл балансад тусгагдах хэрэгжих зээлийн зардлыг хэмжиж, хүлээн зөвшөөрөхдөө санхүүгийн хэрэглүүрийг гурван шатлалд ангилах замаар зээлийн үнэлгээний бууралт, өсөлтийг тусгахыг зорьсон. Үнэлгээний хувьд буураагүй хэрэглүүрийг 1-р шатлалд ангилж, 12 сарыг хамарсан хэрэгжих зээлийн зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Хэрэв зээлийн эрсдэл мэдэгдэхүүд хэмжээний нэмэгдвэл тухайн хэрэглүүрийг 2 эсвэл 3 дахь шатлалд ангилж, тухайн хэрэглүүрийн бүх хугацааг хамарсан хэрэгжих зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Банк, санхүүгийн байгууллагын хувьд хөрөнгийн үнэ цэнийн бууралтын хасагдуулсан буюу эрсдэлийн санг нэмэгдүүлэх нь 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаанд шууд нөлөө үзүүлэх болно.

Практикт тулгарч буй асуудал ба түүнийг шийдвэрлэх арга зам

Дэлхийн олон улс оронд СТОУС 9-ийг мөрдөж эхлээд даруй хоёр тайлант жилийг үдээд байна. Европын банкны удирдах байгууллага (European Banking Authority), Эрнст энд Янг аудитын байгууллага, Делойт аудитын байгууллага, Энэтхэг улсын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтийн Нягтлан бодох бүртгэлийн стандартын Зөвлөл зэрэг мэргэжлийн байгууллагууд СТОУС 9-ийн нэвтрүүлэлтийн үр нөлөөг тогтоохын тулд банк, санхүүгийн байгууллагуудыг хамруулан судалгаа хийсэн.

Хүснэгт 1. СТОУС 9-ийн үр нөлөөг тодорхойлсон судалгааны тойм

Үзүүлэлт	Европын банкны удирдах байгууллага [1]	Эрнст энд Янг аудитын байгууллага [2]	Делойт аудитын байгууллага [4]	Энэтхэг улсын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт [7]
Хамрагдсан байгууллага	Европын бүс нутгийн 51 банк	Олон улсад үйл ажиллагаа явуулдаг 20 том банк	Европ, Дундад Ази, Африк, Америк тивийн 91 банк	СТОУС мөрддөг 26 улсын 75 банк, санхүүгийн байгууллага
Хийгдсэн судалгааны тоо буюу давтамж	3 удаа	3 удаа	6 удаа	1 удаа

Анхны судалгааг хийсэн хугацаа	2016 оны 11 сар	2016 оны 4-р сар	2011 оны 5-р сар	-
Сүүлийн судалгааг хийсэн хугацаа	2018 оны 12-р сар	2018 оны 7-р сар	2020 оны 1-р сар*	2019 оны 7-р сар

* СТОУС-ийн банканд цэцэглэх үр нөлөөний 6 цуврал судалгааг 2016 онд хийсэн ба цүний дараа 2019 онд Их Британы томоохон банкуудыг хамарсан судалгаа, 2020 оны 1-р сард Ази тивийн улс орнуудын томоохон банкуудыг хамарсан судалгааг тус тус хийсэн.

Түүнчлэн Би Ди Өү аудитын байгууллага, Америкийн Санхүүгийн бүртгэлийн стандартын зөвлөл (FASB), Муудийз аналитикс, Их Британийн Хатан хааны Сангийн яам, Их Британийн төв банк гэх зэрэг хувийн хэвшлийн төдийгүй мэргэжлийн олон нийтийн болон төрийн байгууллагуудын зүгээс СТОУС 9-ийн нэвтрэлттэй холбоотой судалгааг тусгайлан хийж, түүний үр нөлөөг гаргасан.

Дээрх байгууллагуудын удаа дараалан хийсэн судалгааны үр дүнд дараах нийтлэг дүгнэлтэнд хүрсэн. Үүнд:

- СТОУС 9-тэй холбоотойгоор үүссэн өөрчлөлт нь санхүүгийн хэрэглүүрийн ангилал ба хэмжилт, үнэ цэнийн бууралт, хейджийн нягтлан бодох бүртгэлийн хүрээг хамарсан хэдий ч банкууд үнэ цэнийн бууралтанд илүү анхаарал хандуулж байсан: Учир нь СТОУС 9-ийг мөрдөх үед үүсэх нийт зөрүү дүнгийн дийлэнх нь санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралттай холбоотой байсан.
- Цөөн банкны хувьд санхүүгийн хэрэглүүрийн ангилал, хэмжилттэй холбоотой СТОУС 9-ийн заалтын үр нөлөө ажиглагдсан. Санхүүгийн хөрөнгийн ангиллыг өөрчилснөөр банкны өөрийн хөрөнгөнд нөлөө үзүүлж байгаа хэдий ч энэ нь банкны бизнес загвар, балансын бүтцээс шалтгаалан бага хэмжээний өөрчлөлтийг бий болгож байна.
- Санхүүгийн хөрөнгийн ангиллыг СТОУС 9-ийн дагуу өөрчлөхөд дийлэнх хэсэг нь хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгөөр ангилагдсан. Европын зарим улсын банкуудын хувьд ангиллын хувьд ялгаатай үр нөлөө гарсан. [7]
- СТОУС 9-ийн шаардлагын дагуу санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт нь эрсдэлийн санг нэмэгдүүлж байгаагийн улмаас СТОУС 9-ийг нэвтрүүлсэн тайлант хугацааны эхний өдөр буюу уг стандартад шилжсэн өдрөөр 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дүн дийлэнхдээ буурсан. Тухайлбал, олон улсад үйл ажиллагаа явуулдаг банкуудын хэвлэн нийтэлсэн 2018 оны санхүүгийн тайлангаас харахад СТОУС 9-ийг мөрдсөнөөс бий болсон цэвэр хөрөнгө буюу хувьцаа эзэмшигчдийн өмчийн бууралт нь ЭйчЭсБиСи (HSBC) банкны хувьд 1.6 тэрбум ам.доллар, Барклай (Barclays) банкны

хувьд 2 тэрбум фаунд, Шотландын Эзэн Хааны банк (RBS plc) -ны хувьд 1.4 сая фаунд болсон байна. Гэхдээ эрсдэлийн санг нэмэгдүүлсэн дүн нь шилжилтээс өмнө урьдчилан таамаглаж байсан дүнгээс харьцангуй бага байсан.

- 2018 оны санхүүгийн тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгийн 80%-90% -ыг 1-р шатлалын хөрөнгөөр ангилж, үнэ цэнийн бууралт тооцсон байна.
- Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэн эсэхийг хэрхэн хэмжих асуудал маргаантай байна. Судалгаанд хамрагдсан дийлэнх банк зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тогтоохдоо төлбөр хойшлогдсон эсэхийг харгалзах ба хугацаа хэтрэлтийг 30 хоногоор авч үзсэн.
- Зээлийн эрсдэлийг хэмжихдээ стандарт арга хандлага ашигладаг банкны хувьд шилжилтийн өдрөөрх СТОУС 9-ийн дагуу нэмж байгуулж буй эрсдэлийн сангийн хэмжээ нь зээлийн эрсдэлийг хэмжихдээ дотоод үнэлгээнд суурилдаг банкны нэмж байгуулсан эрсдэлийн сангаас харьцангуй бага байсан.

СТОУС 9-ийн хэрэгжилтийг хангахын тулд дараах зүйлсийг цаашид анхаарах хэрэгтэй гэж судалгааны байгууллагууд дүгнэжээ. Үүнд:

- Богино хугацаанд СТОУС 9-ийг амжилттай нэвтрүүлэхийн тулд аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулсан заавар, аргачлал, зөвлөмж, гарын авлага гаргах хэрэгтэй.
- Үр дүнтэй хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай. Аж ахуйн нэгжийн хэмжээнээс үл хамааран сайтар боловсруулсан хөтөлбөрийн тусламжтайгаар СТОУС 9-ийг нэвтрүүлбэл зохилтой ба шилжилтийн хөтөлбөр нь төлөвлөлт, хамтын ажиллагаа, засаглалтыг хамарсан байх хэрэгтэй.
- СТОУС 9-ийг амжилттай нэвтрүүлэхэд банк, санхүүгийн байгууллагуудаас гадна зохицуулах байгууллага ба хөндлөнгийн аудиторуудын үүрэг оролцоо, хамтын ажиллагаа маш чухал байна.
- Мэдээллийн технологид хөрөнгө оруулах шаардлагатай. СТОУС 9-ийг нэвтрүүлэхтэй холбоотойгоор шаардлага хангасан тоо мэдээ, системийн хүчин чадал гэсэн хоёр гол асуудлыг анхаарах ёстой. СТОУС 9-ийн дагуу хийх үнэ цэнийн бууралтын үнэлгээнд ашиглах тоо мэдээ нь НББОУС 39-ийн дагуу хийх үнэлгээнд ашиглагдах тоо мэдээтэй харьцуулахад илүү өргөн хүрээтэй байна. Түүнчлэн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэн эсэхийг үнэлэхдээ өнгөрсөн хугацааны түүхэн тоо мэдээг ашиглана. СТОУС 9-ийн дагуу үнэ цэнийн бууралтыг үнэлэхдээ их хэмжээний мэдээллийг ашиглаж, богино хугацаанд иж бүрэн тооцоолол хийх шаардлагатай болж байна. [2]

Америкийн Санхүүгийн бүртгэлийн стандартын зөвлөл (FASB)-ийн хувьд үндэсний стандартдаа 2016 оны 6-р сарын 16-нд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр өнөөгийн хэрэгжихээр хүлээгдэж буй зээлийн зардлын загвар (expected loss model)-

ыг ашиглан зээлийн зардлыг бүртгэх талаар тусгасан ба уг өөрчлөлтийг АНУ-ийн Үнэт цаас, арилжааны хороо (SEC)-нд бүртгэлтэй аж ахуйн нэгжүүд 2019 оны 12-р сарын 15-аас хойшхи санхүүгийн жилд мөрдөнө. Харин бусад аж ахуйн нэгжүүд уг өөрчлөлтийг 2020 оны 12-р сарын 15-аас хойшхи санхүүгийн жилд мөрдөнө. Заасан хугацаанаас өмнө мөрдөх бол 2018 оны 12-р сарын 15-аас хойшхи санхүүгийн жилд мөрдөнө. Ийнхүү Америкийн үндэсний стандартыг өөрчилж оруулж байгаа нь СТОУС ба Америкийн стандартын нийцлийг хангах оролдлого байсан хэдий ч эдгээр стандартад багтсан үнэ цэнийн бууралтын зарчмууд бага зэрэг ялгаатай болсон. Тухайлбал, зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдээгүй нөхцөлд СТОУС 9-ийн дагуу 12 сарын дотор хүлээгдэж буй зээлийн зардлыг авч үздэг бол Америкийн стандартын дагуу тухайн хэрэглүүрийн бүх хугацаанд хүлээгдэж буй зээлийн зардлыг авч үздэг.

Монгол Улсын хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын олон улсын зохих стандартыг дагаж мөрдөх ёстой. Сангийн сайдын 2014 оны 12-р сарын 23-ны өдрийн 249 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар” нь санхүүгийн хэрэглүүрийн бүртгэл, тайлагналын хувьд СТОУС 9-ийн шаардлагыг ерөнхийд нь багтаасан анхны баримт бичиг болсон ба энэ зааварт багтсан санхүүгийн хөрөнгийн ангилал, холбогдох дансууд нь СТОУС 9 дэх санхүүгийн хэрэглүүрийн ангилал, хэмжилтийн шаардлагад нийцэж байгаа. Гэвч санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт, дериватив, хейдж зэргийг бүрэн хамруулаагүй юм.

Арилжааны банкууд Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хамтарсан тушаалаар баталсан “Банкны нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ыг мөрдөж байгаа ба энэхүү багц материалд багтсан санхүүгийн хэрэглүүрийн бүртгэл, тайлагналыг НББОУС 39-д нийцүүлэн боловсруулсан. СТОУС 9 нь зарчмын хувьд НББОУС 39-өөс ялгаатай стандарт тул хэрэв санхүүгийн хэрэглүүрийг СТОУС 9-д нийцүүлэн бүртгэвэл уг багц материалд орсон үнэт цаасаар оруулсан хөрөнгө оруулалтын ангилал, санхүүгийн хөрөнгөнд эрсдэлийн сан байгуулах зарчим зэрэг нь үндсээрээ өөрчлөгдөнө.

Түүнчлэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтанд сан байгуулахтай холбоотойгоор “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” болон СТОУС хооронд зөрүү үүсдэг тул уг зөрүүг тохируулж өөрийн хөрөнгийн дансанд бүртгэх гэх зэргээр нэмэлт зохицуулалт багц материалд багтсан нь банкны санхүүгийн тайлагналыг СТОУС-д нийцүүлэхэд чиглэсэн арга хэмжээ болсон. Цаашид энэ зөрүүг арилгавал эргэлзээ төрүүлж, асуудал үүсгэсэн энэ тохируулгыг хийхгүйгээр дээрх журамд хөрөнгийн эрсдэлийн санг бүлгийн аргаар үнэлж, төлбөр төлөгдөхгүй байх магадлал (PD), алдагдал үүсэх магадлал (LGD), алдагдал тодорхойлох хүчин зүйл (LIP) зэрэг үзүүлэлтүүдийг ашиглан тодорхойлж байхаар өөрчлөлт оруулбал СТОУС-тай зөрчилдөхгүй болж улмаар дээр тайлбарласан тохируулгыг хийх шаардлагагүй болох юм. Мөн уг өөрчлөлтийг хийхдээ Базелийн

хорооноос гаргасан “Зээлийн эрсдэл, зээлийн хэрэгжих зардлыг бүртгэх удирдамж”-ийг баримтлах нь зүйтэй юм.

Хэдийгээр банкинд мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн зааварт өөрчлөлт ороогүй боловч зарим банкууд хувьцаа эзэмшигчид, зээлдүүлэгчид болон бусад гаднын мэдээлэл хэрэглэгчдийн шаардлага, хөндлөнгийн аудитын байгууллагын зөвлөмжийн дагуу СТОУС 9-д нийцүүлэн санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулж байгааг тэдний хэвлэн нийтэлсэн санхүүгийн тайлан, аудиторын дүгнэлтээс харж болно. Тухайлбал, Худалдаа Хөгжлийн банкны хэвлэн нийтэлсэн 2018 оны жилийн тайланд СТОУС 9-д нийцүүлэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцоолох бэлтгэл ажил хангагдсан гэж банкны удирдлага үзсэн ба хараат бус аудиторын дүгнэлтэнд тус банкны санхүүгийн тайлан СТОУС-д тулгуурлан Монголбанкнаас баталсан заавар журамд нийцсэн байна гэж дүгнэжээ. Харин Хаан банк, Төрийн банкны хувьд хараат бус аудиторын дүгнэлтээр 2018 ба 2019 санхүүгийн тайланд СТОУС -д нийцсэн байна гэжээ.

Банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаасны компани гэх зэрэг санхүүгийн бусад байгууллага нь санхүүгийн бүртгэл, тайлагналдаа Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ноос гаргасан заавар журмыг мөрдөж байгаа боловч СЗХ-оос баталж, мөрдүүлж буй нягтлан бодох бүртгэлийн зарим зааварт СТОУС 9-ийн шаардлагыг мөн л тусгаагүй байсаар байна.

Хамгийн сүүлд өөрчлөгдөн батлагдсан нь “Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн заавар” ба үүнийг НББОУС 39-д нийцүүлэн 2015 онд шинэчлэн өөрчилсөн.

Дээрх байдлаас дүгнэхэд манай улсад санхүүгийн байгууллагын хүрээнд СТОУС 9-ийн мөрдөлт хангалтгүй байгаа ба үүний улмаас тэдгээр байгууллагын бэлтгэн гаргасан санхүүгийн тайлан санхүүгийн бусад мэдээлэлд итгэх мэдээлэл хэрэглэгчдийн итгэл багасч болзошгүй байна. Ялангуяа зах зээлд оролцогч гадаадын томоохон хэрэглэгчдийн хувьд санхүүгийн мэдээллийн үнэн зөв, зохистой бөгөөд зэрэгцүүлэгдэх чанарыг хангах үүднээс СТОУС 9-ийг мөрдөх шаардлага эргэлт буцалтгүй тавигдаж байна. Иймд юуны өмнө эрх бүхий байгууллага банк, санхүүгийн байгууллагын мэргэшсэн албан хаагчид, судлаачдаас бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулан, нягтлан бодох бүртгэлийн холбогдох заавар, журам боловсруулан гаргаж, шаардлагатай туршилт, судалгааг зайлшгүй хийх шаардлагатай.

Ялангуяа дээр дурдсан дэлхийн бусад орнуудын судалгаанд дурдсан энэхүү стандартыг нэвтрүүлсэн шилжилтийн өдрөөрх үр нөлөө, түүний улмаас цэвэр хөрөнгө, үнэ цэнийн бууралтын санд гарсан өөрчлөлтийн зэргийг гаргаж, харьцуулсан судалгаа хийвэл ач холбогдол ихтэй байх болно.

СТОУС 9-д нийцүүлэн банк, санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар журмыг өөрчлөхдөө үнэт цаасны ангилал, бүртгэлийг шинэчлэн, санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт, дериватив, хейдж зэргийг хамарсан өөрчлөлтийг хийх

хэрэгтэй байна. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг СТОУС 9-ийн дагуу тооцоолох, санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн үнэлгээ хэмжилтийг хийхэд зохих мэдээллийн сан, туршлага хуримтлуулсан байх шаардлага тавигддаг тул үүний бэлтгэлийг урьдаас хангаж ажиллах нь чухал юм. Бусад улс орнуудын туршлагаас харахад маш нарийн төлөвлөж, оновчтой арга хэмжээ авч чадвал, СТОУС 9-ийг амжилттай бүрэн нэвтрүүлэн, хөрсөн дээрээ буулгах боломж харагдаж байна.

Дүгнэлт

Санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, үнэ цэнийн бууралтын шаардлага нь дэлхий даяарх мэдээлэл хэрэглэгчдийн нийтлэг хэрэгцээ шаардлагад зориулагдсан байдаг учраас СТОУС 9-ийн дагуу санхүүгийн хөрөнгийг ангилахдаа тухайн хэрэглүүрийг хэмжих үнэлгээний аргачлалд тулгуурласан байдаг. Энэ нь санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд илүү ойлгомжтой төдийгүй санхүүгийн мэдээллийн чанарыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Дэлхий нийтээр санхүүгийн хэрэглүүрийн нягтлан бодох бүртгэл, тайлагналд СТОУС 9-ийг мөрдөхөөр хийж буй шилжилтийг эхлүүлээд даруй хоёр жил болжээ. Энэ хугацаанд уг стандартын үр нөлөөг ихээр мэдэрч байгаа томоохон банк, санхүүгийн байгууллагууд багагүй туршлага хуримтлуулж, тэдний нөхцөл байдлыг мэргэжлийн байгууллагууд тасралтгүй ажиглан судалж ирлээ. Мэргэжлийн байгууллагуудын хийсэн судалгааны үр дүнгээс дүгнэхэд СТОУС 9-д шилжсэн өдрөөрх үр нөлөө материаллаг хэмжээтэй бөгөөд санхүүгийн байгууллагын эздийн өмчид сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн СТОУС 9-ийг нэвтрүүлэх шилжилт зарим талаараа бүрэн хийгдээгүй байгаа ба зарим улс орон, тухайлбал манай улсын аж ахуйн нэгж, байгууллагын хувьд хангалтгүй байгаа тул энэ шилжилтийг амжилттай хэрэгжүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллага төдийгүй эрх бүхий төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хараат бус хөндлөнгийн аудитын байгууллагын оролцоо, хамтын ажиллагаа нэн чухал байна.

Манай улсын хувьд СТОУС 9-ийг нэвтрүүлэх ажлыг нэн даруй зохистойгоор хэрэгжүүлснээр санхүүгийн мэдээллийн ач холбогдлыг нэмэгдүүлэх чанарын шинж (үнэн зөв толилуулгын болон хамааралтай байх, түүнчлэн ойлгомжтой болон зэрэгцүүлэгдэх байдал) бүрэн хангагдаж стандартын энэхүү хэрэгжилт нь санхүүгийн зах зээлийн хөгжилд зохих хувь нэмэр оруулах болно.

Ашигласан материал

- [1] European Banking Authority, EBA REPORT – First Observations on the Impact and Implementation of IFRS 9 by EU Institutions, 2018
- [2] Available at:
- [3] <https://eba.europa.eu/sites/default/documents/files/documents/10180/2087449/bb4d7ed3-58de-4f66-861e-45024201b8e6/Report%20on%20IFRS%209%20impact%20and%20implementation.pdf>
- [4] Ernst & Young audit firm, EY IFRS 9 Impairment Banking surveys 2015-2018, 2018
- [5] Available at:
- [6] [https://www.ey.com/Publication/vwLUAssets/ey-ifs-9-survey-impairment-survey-challenges-remain/\\$FILE/ey-ifs-9-survey-impairment-survey-challenges-remain.pdf](https://www.ey.com/Publication/vwLUAssets/ey-ifs-9-survey-impairment-survey-challenges-remain/$FILE/ey-ifs-9-survey-impairment-survey-challenges-remain.pdf)
- [7] Deloitte audit firm, Sixth Global IFRS Banking Survey – No time like the present, 2016
- [8] Available at:
- [9] <https://www2.deloitte.com/content/dam/Deloitte/global/Documents/Financial-Services/gx-fsi-sixth-ifs-banking-survey.pdf>
- [10] Deloitte audit firm, After the first year of IFRS 9 - Analysis of the initial impact on the large UK banks, 2019
- [11] Available at:
- [12] <https://www2.deloitte.com/content/dam/Deloitte/uk/Documents/financial-services/deloitte-uk-fs-ifs9-analysis-of-the-initial-impact-on-the-large-uk-banks.pdf>
- [13] Марна Cacamero, Michael McDonald, and Yagmur Uenal, IFRS 9 Survey Results, Moody’s analytics “Risk perspectives”, 2016
- [14] Available at:
- [15] <https://www.moodyanalytics.com/risk-perspectives-magazine/risk-finance-accounting-converge-ifs9/spotlight-ifs-9/ifs-9-survey-results>
- [16] Petra Blažeková, The Impact of IFRS 9 (Increase in Credit Risk Provisioning) on Banks’ Regulatory Capital, 2018
- [17] Available at:
- [18] https://www.researchgate.net/publication/322741600_THE_IMPACT_OF_IFRS_9_INCREASE_IN_CREDIT_RISK_PROVISIONING_ON_BANKS'_REGULATORY_CAPITAL

- [19] Accounting Standards Board The Institute of Chartered Accountants of India, A Study: Transition Impact on Banks Across the Globe, 2019
- [20] Available at:
- [21] <http://www.caparivaar.in/wp-content/uploads/2019/07/ICAI-Publication-dated-July-29-2019.pdf>
- [22] Bank of England, Mahmoud Fatouh, Robert Bock and Jamal Ouenniche, Staff Working Paper No. 851, Impact of IFRS 9 on the cost of funding of banks in Europe,
- [23] Available at:
- [24] <https://www.bankofengland.co.uk/working-paper/2020/impact-of-ifrs-9-on-the-cost-of-funding-of-banks-in-europe>
- [25] International Financial Reporting Standards (IFRS) 9, 2019
- [26] The Basel Committee, Guidance on credit risk and accounting for expected credit losses, 2016
- [27] Available at:
- [28] [https://www.ey.com/Publication/vwLUAssets/The_Basel_Committee_Guidance_on_credit_risk_and_accounting_for_expected_credit_losses/\\$FILE/FI-G-CRAECL-Jan2016.pdf](https://www.ey.com/Publication/vwLUAssets/The_Basel_Committee_Guidance_on_credit_risk_and_accounting_for_expected_credit_losses/$FILE/FI-G-CRAECL-Jan2016.pdf)
- [29] Сангийн сайдын 2014 оны 12-р сарын 23-ны өдрийн 249 тоот тушаалын хавсралт, Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар
- [30] <https://www.legalinfo.mn/annex/details/5201?lawid=7495>
- [31] Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайддын 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хамтарсан тушаал А-294/340 -ын хавсралт, Банкны нягтлан бодох бүртгэлийн багц материал
- [32] https://www.mongolbank.mn/documents/regulation/control_check/20180205_3848.pdf
- [33] Санхүүгийн Зохицуулах Хорооны 2008 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 5-р тогтоолын хавсралт, Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар
- [34] <http://www.frc.mn/resource/frc/Document/2020/02/20/uc4siobjqalyiea1/a3.pdf>
- [35] Сангийн Сайд, Санхүүгийн Зохицуулах Хорооны Даргын 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хамтарсан 221/331 тушаалын хавсралт, Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн заавар
- [36] <https://mof.gov.mn/files/uploads/legacy/2017-221.pdf>
- [37] <https://www.iasplus.com/en/standards/ifrs/ifrs9>